



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ТӨВИЙН
2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/30/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Г.Золбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: ZolbayarG@audit.gov.mn

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал.....	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
4.5.1 Завсрын аудитын талаар.....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
5.1 Төлбөрийн акт.....	12
5.2 Албан шаардлага.....	13
5.3 Зөвлөмж	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ,ЗДНХөрөнгө	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.24 № 01/25
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд нийт 6,141.2 мянган төгрөгийн ажиллагсадтай холбогдсон өглөг шинээр үүссэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8, "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв нь тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас борлуулалтыг дэмжих хөтөлбөрийн дагуу 17,200.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны түрээсийн орлогоор 78,701.0 мянган төгрөг, нийт 95,901.0 мянган төгрөгийн орлого олсон нь өнгөрсөн оноос 37,052.9 мянган төгрөг буюу 62.9 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

4525020188

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус төв нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор нэмэгдүүлсэн төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээтэй дүйцүүлэн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлсэн 4 орон тоо дутуу ажиллаж цалингийн зардал 8 хувиар буурсан байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан-Уул аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргатай байгуулсан гэрээнд 12 зорилт 53 арга хэмжээг тусгасан бөгөөд гүйцэтгэлийн биелэлтийг 2024 оны 12 сарын 19-ний өдрийн А/429 тоот тушаалаар 88.12 хувьтай дүгнэсэн байна. Тус гэрээнд Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн борлуулалтыг дэмжих хөтөлбөр багтсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,662,380.67</u>	<u>18,388,376.95</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,359,148.41	11,041,916.95
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	282,513.43	3,371,766.43
31110	Төгрөг	282,513.43	3,371,766.43
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,076,634.98	7,670,150.52
3121	Төгрөг	1,076,634.98	7,670,150.52
31213	Арилжааны банк дахь харилцах	1,076,634.98	7,670,150.52
33	АВЛАГА	2,337,047.00	-
335	Бусад авлага	2,337,047.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,337,047.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	3,966,185.26	7,346,460.00
354	Хангамжийн материал	3,966,185.26	7,346,460.00
35410	Бичиг хэргийн материал	239,315.26	150,860.00
35420	Аж ахуйн материал	3,726,870.00	3,314,600.00
35470	Бусад хангамжийн материал	-	3,881,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>483,376,233.85</u>	<u>469,340,334.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	483,016,233.85	469,340,334.97
391	Газар	47,150,000.00	47,150,000.00
392	Биет хөрөнгө	434,114,233.97	421,758,335.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	518,250,581.00	518,250,581.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(113,704,579.56)	(122,342,089.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	21,880,610.00	21,880,610.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,588,829.64)	(21,280,609.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,172,900.00	7,172,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,172,900.00)	(7,172,900.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,409,500.00	37,409,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,133,047.83)	(12,159,657.39)
393	Биет бус хөрөнгө	1,751,999.88	431,999.88
39301	Програм хангамж	50,480,000.00	50,480,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(48,728,000.12)	(50,048,000.12)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>491,038,614.52</u>	<u>487,728,711.92</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>38,016,688.68</u>	<u>37,815,436.08</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	38,526,688.68	37,815,436.08
413	Өглөг	38,526,688.68	37,815,436.08
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	32,034,274.68	37,815,436.08
4136	Бусад өглөг	6,492,414.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	6,492,414.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>452,511,925.84</u>	<u>449,913,275.84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	446,650,000.00	449,913,275.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	446,650,000.00	446,650,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	446,650,000.00	446,650,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	(101,621,155.16)	(104,219,805.16)
51210	Өмнөх үеийн үр дүн	(101,621,155.16)	(110,050,118.97)
51220	Тайлант үеийн үр дүн	-	5,830,313.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	107,483,081.00	107,483,081.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>491,038,614.52</u>	<u>487,728,711.92</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	58,848,183.00	95,901,034.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,848,183.00	95,901,034.00
120	Нийтлэг татварын бус орлого	58,848,183.00	95,901,034.00
120003	Торгуулийн орлого	116,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	58,724,553.00	95,901,034.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,438,500.00	17,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,286,053.00	78,701,034.00
120009	Бусад орлого	7,630.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	127,253,298.70	90,070,720.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	127,253,298.70	90,070,720.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	127,253,298.70	90,070,720.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,848,895.11	44,957,460.48
210101	Үндсэн цалин	44,616,160.41	42,810,596.79
210102	Нэмэгдэл	4,032,734.70	2,146,863.69
210105	Гэрээт ажлын хөлс	200,000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,628,298.79	5,135,232.40
210201	Тэтгэврийн даатгал	5,628,298.79	5,135,232.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,902,900.00	19,004,538.17
210301	Гэрэл, цахилгаан	9,175,174.00	9,334,031.00
210302	Түлш, халаалт	7,427,726.00	4,311,049.30
210303	Цэвэр, бохир ус	2,300,000.00	5,359,457.87
2104	Хангамж, бараа материалын зардал	8,316,468.74	1,926,777.26
210401	Бичиг хэрэг	775,718.42	178,455.26
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,951,971.00	668,250.00
210404	Ном, хэвлэл	407,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,030,072.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,181,779.32	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,897,636.50	1,878,270.00
210604	Урсгал засвар	12,897,636.50	1,878,270.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,462,275.00	3,492,543.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,039,700.00	3,049,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		224,443.00
210807	Газрын төлбөр		188,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	176,500.00	30,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	246,075.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,196,824.56	13,675,898.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	711,606.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	745,250.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,739,968.56	13,675,898.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(68,405,115.70)	5,830,313.81
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(68,405,115.70)	5,830,313.81

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	59,147,630.00	91,172,919.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,147,630.00	91,172,919.00
120	Нийтлэг татварын бус орлого	59,147,630.00	91,172,919.00
120003	Торгуулийн орлого	116,000.00	658,080.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,058,630.00	90,514,839.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,750,000.00	17,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,645,582.00	73,314,839.00
120009	Бусад орлого	663,048.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	62,923,034.38	81,490,150.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,923,034.38	81,490,150.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,923,034.38	81,490,150.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,499,588.48	41,353,881.29
210101	Үндсэн цалин	26,199,588.48	39,853,881.29
210105	Гэрээт ажлын хөлс	300,000.00	1,500,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	10,340,000.00
210201	Тэтгэврийн даатгал	-	10,340,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,121,914.00	18,465,324.17
210301	Гэрэл, цахилгаан	9,377,148.00	8,794,817.00
210302	Түлш, халаалт	5,444,766.00	4,311,049.30
210303	Цэвэр, бохир ус	2,300,000.00	5,359,457.87
2104	Хангамж, бараа материалын зардал	7,818,396.00	2,264,115.00
210401	Бичиг хэрэг	210,500.00	90,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,232,957.00	837,693.00
210404	Ном, хэвлэл	407,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, ариутгал	-	200,000.00
210406		-	1,399,650.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,967,939.00	1,186,422.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,970,004.90	4,371,000.00
210604	Урсгал засвар	7,970,004.90	4,371,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,056,275.00	2,218,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,039,700.00	609,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	594,000.00	-
210807	Газрын төлбөр	-	188,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	176,500.00	30,500.00
210810	Хөтөлбөр арга хэмжээний зардал	246,075.00	-
210813	Харуул хамгаалалтын зардал	-	1,390,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,456,856.00	1,028,080.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	711,606.00	1,028,080.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	745,250.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(3,748,404.38)	9,682,768.54
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	=
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(3,748,404.38)	9,682,768.54
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,107,552.79	1,359,148.41
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,359,148.41	11,041,916.95

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	446,650,000.00	107,483,081.00	(33,216,039.46)		520,917,041.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-			-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	446,650,000.00	107,483,081.00	(33,216,039.46)	-	520,917,041.54
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн			(68,405,115.70)		(68,405,115.70)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	446,650,000.00	107,483,081.00	(101,621,155.16)	-	452,511,925.84
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	446,650,000.00	107,483,081.00	(170,026,270.86)	-	452,511,925.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(8,428,963.81)		(8,428,963.81)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	446,650,000.00	107,483,081.00	(110,050,118.97)	-	444,082,962.03
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			5,830,313.81		5,830,313.81
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	446,650,000.00	107,483,081.00	(104,219,805.16)	-	449,913,275.84

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Жижиг Дунд үйлдвэрийг дэмжих төв нь хууль зүйн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж болон гарааны бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх замаар зах зээлд бие даан хөгжих чадвартай бизнес эрхлэгч болгон хөгжүүлэх, төлөвшүүлэх зорилготой байгууллага юм.

Тус байгууллага 2024 онд жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, бизнесийн сургалт явуулах, зөвлөгөө өгөх, мэдээллийн нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус төв нь Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байна.

Төсвийн шууд захирагч төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 487,728.7 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,359.1	11,041.9	9,682.8
Авлага	2,337.0	0	(2,337.0)
Бараа материал	3,966.2	7,346.5	3,380.4
Үндсэн хөрөнгө	483,016.2	469,340.3	(13,675.9)
Нийт хөрөнгө	491,038.6	487,728.7	(3,309.9)
Өр төлбөр	38,526.7	37,815.4	(711.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	452,511.9	449,913.3	(2,598.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	491,038.6	487,728.7	(3,309.9)

Мөнгөн хөрөнгийн 9,682.8 мянган төгрөг нь 2024 оны 12 дугаар сард Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 10,800.0 мянган төгрөгийн борлуулалтыг дэмжих хөтөлбөрийн орлого шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өмнөх онд үүссэн 2,337.0 төгрөгийн авлагыг тайлант онд бүрэн барагдуулж ажилласан байна.

Бараа материалын данс 3,380.4 мянган төгрөгөөр өссөн нь харуул хамгаалалтын дохиоллын систем суулгасантай холбоотойгоор бусад хангамжийн материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн бууралтад тайлант оны 13,675.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Өр төлбөрийн данс 711.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны байгууллагад төлөх 6,342.4 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо 2,598.6 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалсан тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төв нь төсвөөс санхүүжилт авдаггүй, төрийн өмчийн түрээсийн орлого болон үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүждэг байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тус байгууллага нь төсвөөс санхүүжилт аваагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого төвлөрүүлж, зарцуулалт хийдэггүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Жижиг дунд үйлдвэрийн дэмжих төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн өр төлбөртэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын аудитор Г.Золбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн 2024 оны санхүүгийн тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/01 дугаар тоот албан бичгээр 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны хагас жилийн тайлангаарх нийт хөрөнгө 491,038.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,910.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих 23,693.5 мянган төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байгаа тул Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж байх, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 39,184.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 658.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 38,526.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн бөгөөд 2024 оны 05 дугаар сарын 30-ний өдрөөр хэрэгжилтийг шалгахад 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	658.1	1	658.1	100
Албан шаардлага	-	-	-	-	100
Зөвлөмж	1	38,526.7	1	38,526.7	100
Нийт дүн	2	39,184.8	2	39,184.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 29,950.5 мянган төгрөгийн зөрчилд¹ 115.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах 29,834.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө. Үүнд:

¹ Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд захирал, бичиг хэргийн ажилтны 115.8 мянган төгрөгийн гар утасны төлбөрийг байгууллагын зардлаас төлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.1 “Үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад бусад гар утасны зардал” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт

Тайлант онд 6,141.2 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.8, “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж

Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, дараагийн тайлант онд шинээр өр төлбөр үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжөөс гадна тайлангийн 4.4.1 дэх хэсэгт дурдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 6,141.2 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүссэн байна.	1	6,141.2	-	-	-	-	1	6,141.2	-	-	-	-
Захирал, бичиг хэргийн ажилтны гар утасны төлбөрийг байгууллагын зардлаас төлсөн.	1	115.8	1	115.8	-	-	-	-	-	-	-	-
Дүн	2	6,6257.0	-	115.8	-	-	1	6,141.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих 3 мэдээллийг байршуулаагүй.	1	23,693.5	-	-	-	-	1	23,693.5	-	-	-	-
Дүн	1	23,693.5	-	-	-	-	1	23,693.5	-	-	-	-